

БАТЛАВ
БАЯНХОНГОР АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНЫ
ДЭД ДАРГА ГЭНХБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ "БАЯНХОНГОР АЙМГИЙГ 2020 - 2024 ОНД ХӨГЖҮҮЛЭХ"
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 08 сарын 05

Баянхонгор

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Орлоготой иргэн

Орлоготой иргэн зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх замаар шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэд, их дээд сургуулиудтай хамтарч технологи, инновац, судалгаа шинжилгээний төв байгуулж орон нутгийн тувшинд хөгжих боломжтой үйлдвэрүүдийг тодорхойлон, үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлнэ.


- 1.1.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац"-аар дамжуулан бага хүүтэй зээл олгоно.
- 1.1.2 Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.
- 1.1.3 Өрхийн сёдлын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг бүх сумдад хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлж аймгийн онцлогтой, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Шинжлэх ухааны байгууллага, их дээд сургуулиудтай хамтарсан компани байгуулна.
- 1.1.5 Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Хөдөө орон нутгийн хүн амын хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.7 Иргэдийн туршлага ур чадварт түшиглэн хувиараа хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжин, шаардлагатай техник тоног төхөөрөмжийн хөнгөлөлттэй зээл олгоно.

1.2 Эрүүл иргэн

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны "Жишиг загвар төв" байгуулж, иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ. "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, бага насны хүүхдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх "Эрүүл ирээдүй" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

- 1.2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны "Жишиг загвар төв" байгуулна.

• 000000001



- 1.2.2 Эрүүл мэндийн оношилгооны чадавхыг дээшлүүлж, эмч, мэргэжилтнийг нарийн мэргэжлээр бэлтгэн, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.3 Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.2.4 "Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөрийг үргэлжлүүлж, "Хавдрын эсрэг хамтдаа" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2.5 "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдийн хоолойн архаг /ангина/ өвчнийг эрт илрүүлэн эмчлэх, ирээдүйд учрах эрүүл мэндийн эрсдэлээс бага насанд нь сэргийлж, "Эрүүл ирээдүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.6 Эмэгтэйчүүдийн товлолт дархлаажуулалтыг аймгийн хэмжээнд нэвтрүүлж, умайн хүзүү, хөхний хорт хавдраас сэргийлэн эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн "Энх бүсгүй" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.7 Эмч, эмнэлгийн мэргэжилтний хөгжил, ур чадварыг тасралтгүй дэмжиж, гадаад дотоодын сургалт, үйл ажиллагаанд хамруулан "Цогц чадамжтай эмч" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.8 Эрүүл мэндийн байгууллагын ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулан, нийгэмд эерэг хандлагыг бий болгоход чиглэсэн "Эрүүл мэндийн салбарын эелдэг ажилтан" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.2.9 Бэлгийн замаар дамжих халдварт, сурьеэгийн халдвартыг улс, аймгийн дунджаас бууруулан, урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.2.10 Охидын жирэмслэлт, үр хөндөлт төрөлтийг бууруулан, өсвөр насын охидын нөхөн үржихүйн эрүүл мэндэд учрах эрсдэлээс сэргийлж, зорилтот үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 1.2.11 Ахмад настны эрүүл мэндийг дэмжиж, эмчилгээний дараах сувилахуй болон нөхөн сэргээх төрөлжсөн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.
- 1.2.12 Идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэх дасгал, эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн зориулалтын зам, талбай, цогцолборуудыг байгуулж, халдварт бус өвчлөлийг бууруулан, хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.
- 1.2.13 Баянхонгор аймгийн Богд, Заг сумын Эрүүл мэндийн төвд их засвар, Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл, Гурванбулаг, Жаргалант, Баян-Овоо сумдад шинэ эрүүл мэндийн төв барина.

1.3 Чанартай боловсрол шинжлэх ухаан, инновацийн хөгжил

Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ сургууль, цэцэрлэгүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, суралцагчдын сурах таатай нөхцөлийг бүрдүүлж, сурлагын чанарыг дээшлүүлнэ.

- 1.3.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийг бэлтгэх, тогтворт суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.2 Тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах дохионы хэлний багш бэлтгэхэд дэмжин ажиллана. /29 сургуулийн 1 багш*3000,0/
- 1.3.3 Олон улсын хөтөлбөртэй чанарын шаардлага хангасан хувийн хэвшлийн сургууль байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

• 000000002





- 1.3.4 Өдөр өнжүүлэх бүлгийн ажиллах журмыг боловсруулан хэрэгжүүлнэ. /20 сүм*2000,0/
- 1.3.5 Боловсролын салбарын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.3.6 Орон нутаг дахь их дээд сургууль, коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг сайжруулах, суралцагчдын тоог нэмэгдүүлэн ажиллана.
- 1.3.7 Эрдэм шинжилгээ, судалгааны багийг байгуулж, салбаруудтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.8 Эрдэнэмандал ахлах сургуулийг спортын төрөлжсөн сургууль болгон хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 1.3.9 Иргэдийн эрүүл мэнд, бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.10 Хувь хүн, гэр бүл, байгууллагын соёлыг төлөвшүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.3.11 Богд, Баянговь, Баян-Өндөр, Бөмбөгөр, Жаргалант, Галуут сумдад 240 хүүхдийн сургууль, Эрдэнэцогт сумын 3-р багийн бага сургуулийн барилга шинээр барина. Баацагаан, Хүрээмарал сумдад сургуулийн барилгын их засвар, Шинэжинст сумд сургуулийн дотуур байрны барилгын их засвар хийнэ.
- 1.3.12 Жинст, Баян-Өндөр, Бууцагаан, Гурванбулаг, Баянбулаг, Жаргалант, Галуут сумдад цэцэрлэгийн барилга, Эрдэнэцогт сумын 3-р багийн цэцэрлэгийн барилга шинээр барьж, Хүрээмарал, Баацагаан сумдад цэцэрлэгийн барилгын их засвар хийнэ. Баянхонгор хотын 2,4 дүгээр цэцэрлэгийг төлөвлөлтэд оруулж барина. Мөн шинээр 3-аас доошгүй цэцэрлэг барина.
- 1.3.13 Сургуулиудын гадна талбайд спорт цогцолбор байгуулна.
- 1.3.14 Сурагчдын сурлагын амжилт, чанар, стандарт хангалтыг сайжруулах бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлнэ.

1.4 Тогтвортой - Амар амгалан гэр бүл

Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлж, гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгох замаар гэр бүл төлөвлөлтийг сайжруулна.

- 1.4.1 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.4.2 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамж үйлчилгээг төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4.3 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах, тогтвортой суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.4 Хөдөлмөр эрхлэлт зуучлалын үйлчилгээг хэрэгжүүлэх бодлого боловсруулан ажиллана.
- 1.4.5 Гадаадад хөдөлмөр эрхэлж мэргэжил эзэмшиж буй иргэдийн мэдээллийн санг бүрдүүлж, тэдний орон нутагтаа хөдөлмөрлөх, бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.6 Гэр бүл дэх эцэг эхчүүдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулна.

• 000000003



- 1.4.7 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.5 Хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр

Хүүхэд, багачуудын бие даах чадварыг хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч, хүүхдийн өсөж хөгжих, чөлөөт цаг өнгөрөөх орчныг нэмэгдүүлнэ.

- 1.5.1 Хүүхдийн хөгжил, хамгаалал, төлөвшлийг сайжруулах орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.5.2 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.5.3 Хүүхдийн хүчирхийлэл, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна.
- 1.5.4 Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, камертай болгоно.
- 1.5.5 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.5.6 Баянхонгор суманд Хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газруудын тоог нэмэгдүүлнэ.
- 1.5.7 Хүүхдийн болон ахмадын сэргээн засах сувилал байгуулна.
- 1.5.8 Жаргалант паркийг хүүхдийн парк болгон тохижуулах ажлыг эхлүүлнэ.

1.6 Залуучуудыг дэмжих чиглэлээр

Залуучуудын хөгжиж дэвжих орчныг бүрдүүлж орчин үеийн тоног төхөөрөмжээр хангасан төв байгуулах замаар нийгмийн оролцоог нэмэгдүүлж, залуус эрч хүч, дуу хоолой, хичээл зутгэлээ нийгмийн сайн сайханд зориулдаг байх нөхцлийг бүрдүүлнэ.


- 1.6.1 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлэн идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6.2 “Залуус бидний төлөө -бид залуусын төлөө” төсөл хэрэгжүүлж, залуусын оролцоотой төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 1.6.3 Залуу гэр булийг дэмжсэн бодлого боловсруулан, гэр бүл төлөвлөлт, харилцаа хандлагыг дээшлүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6.4 Залуучуудын хөгжлийг хангасан орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төв байгуулна.
- 1.6.5 Баянхонгор сумын газар нутгийг тэлэх зорилгоор нисэх буудлыг нүүлгэх судалгааны ажлыг эхлүүлнэ.

1.7 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийг дэмжих

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлж, тэдэнд зориулсан төрийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

- 1.7.1 Тусгай хэрэгцээ /Хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдийн нөхөн сэргээх, сэргээн засах эмчилгээний тусгай эмнэлэг, сувиллын газар байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.7.2 Тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд төрийн нэгдсэн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн төвийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

000000004



- 1.7.3 "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.7.4 Сумдад тусгай хэрэгцээтэй хүүхдийг хөгжүүлэх, тэгш хамран сургах, нөхөн сэргээх өдрийн үйлчилгээг дэмжин ажиллана.
- 1.7.5 Тусгай хэрэгцэ /хөгжлийн бэрхшээлтэй/-тэй хүүхэд, иргэдтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

1.8 Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.

- 1.8.1 Ахмад настны амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх, хөгжих төв, цэцэрлэгт хүрээлэнг байгуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.8.2 Ахмад настанд үзүүлэх үйлчилгээг сайжруулах, хөнгөлөлт эдлүүлэх, дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэхэд төрийн зүгээс үйлчилгээ үзүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.8.3 Баг, сумын харьят ахмад настнуудад чиглэсэн олон талт үйлчилгээг зохион байгуулна.
- 1.8.4 Ахмадуудад зориулсан спорт заал барина.

1.9 Үндэсний бахархал, өв соёл, спорт

Түүх угсаатны зүйн музей, хүүхдийн театр, хүүхдийн номын сан, спорт цогцолборууд, сумдын соёлын төвүүдийг шинэчлэх замаар хүүхдэд зориулсан бүтээл, соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хөгжих орчин бүрдүүлнэ.

- 1.9.1 Соёлын салбарын хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.2 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.9.3 Спортын дасгалжуулагчдыг мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулж, биеийн тамир, спортын арга зүйчийн ажлын байрыг нэмэгдүүлж, сум бүрд биеийн тамирын арга зүйч ажиллуулна.
- 1.9.4 Орон нутагт ажилладаг магадлан итгэмжлэгдсэн спортын клубийг дэмжиж хамтран ажиллана.
- 1.9.5 Тахилгат уул, ус, газар нутгийн мэдээллийн санг бүрдүүлж, тахин шүтэх ёсыг түгээн дэлгэрүүлэх журам боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.9.6 Түүх угсаатны зүйн музейн барилгыг барьж, түүх дурсгалын үзмэрүүдийг олон нийтэд таниулах ажлыг эрчимжүүлнэ.
- 1.9.7 Хүүхдийн театр, хүүхдийн номын сан, хүүхдэд зориулсан бүтээл зэрэг соёлын өвийг түгээн дэлгэрүүлж, хүүхэд хөгжлийн төвүүдэд шаардлагатай сургалт, танин мэдэхүйн дэмжлэг үзүүлнэ.
- 1.9.8 Түүх соёлын өвийг сүйтгэж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.
- 1.9.9 Иргэд идэвхтэй хөдөлгөөн хийх, уулын болон явган аялал, дугуйн спорт зэрэг нийтийн биеийн тамирын төрлийг дэмжиж, хамрах хүрээг өргөжүүлж, стандартын шаардлага хангасан дугуйн замтай болно.
- 1.9.10 Монголын үндэсний баяр наадам, үндэсний спортын язгуур шинжийг хадгалан уламжлуулах сурталчлан таниулах, үндэсний спортын наадмыг зохион байгуулна.

000000005

- 1.9.11 Усан бассейн бүхий спорт цогцолборын барилгын ажлыг дуусгана.
- 1.9.12 Баянхонгор суманд Хүүхэд залуучуудын соёлын ордон, Баян-Өндөр, Баянцагаан, Баян-Овоо сумдад соёлын ордон шинээр барина.
- 1.9.13 Баянхонгор хотод Өвлийн спортыг хөгжүүлэх зорилгоор спорт цогцолбортой болно.
- 1.9.14 Кино театрыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж ашиглалтад оруулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

“Тунгалаг санхүү” хөтөлбөр хэрэгжүүлж санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийн орлого бүрдэлтийг сайжруулан, “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

2.1 Үйлдвэржилтийн бодлого

- 2.1.1 Орон нутгийн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөн төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулж санхүүгийн сахилга батыг сайжруулах, салбарын боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлэх, төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.2 Сумдын бие даан хөгжих эдийн засгийн нөөц бололцоог судалж хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.1.3 Иргэн, айл өрх бүр хуримтлал үүсгэн эдийн засгийн хямралд өртөхөөс сэргийлэх, мөнгөн урсгалыг дотооддоо хадгалан, өрхийн төсөв болон аймаг орон нутгийн эдийн засагт зөргээр нөлөөлөх “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.1.4 Хорио цээрийн дэглэм бүхий мах боловсруулах бүсийн үйлдвэр байгуулна.
- 2.1.5 Дөвөнтийн нүүрсний уурхайг түшиглэн утаагүй шахмал түлшний үйлдвэр байгуулна.
- 2.1.6 Барилгын чулуун материалын үйлдвэр байгуулна.
- 2.1.7 Арьс шир гүн боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.1.8 Галуут, Жаргалант, Бууцагаан сумдад сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна.
- 2.1.9 Баянхонгор сумын утааг бууруулах, иргэдийн тав тухтай, эрүүл орчинд амьдрах байдлыг хангах зорилгоор Дулааны станцыг барьж ашиглалтад оруулна.
- 2.1.10 Сарлагийн хөөврөөр хийсэн бүтээгдэхүүн болон хонины ноосоор хийсэн дулаалгын материалыг зах зээлд нийлүүлж, ноолуур боловсруулах, хонь, тэмээний ноосоор утас ээрэх үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 2.1.11 Хог хаягдлыг дахин боловсруулах эко үйлдвэрийг байгуулж эдийн засгийн эргэлтэд оруулна.


2.2 Төрөлжсөн аялал жуулчлал.

- 2.2.1 Алтай таван Богд, "Бүргэдийн баяр"-ыг үзэхээр зорьдог жуулчдын урсгалыг Баянхонгор аймгаар зочлуулах “Транзит Баянхонгор” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2.2 Төвлөрсөн замын дагуу болон аялал жуулчлалын маршрутаар үйлчилгээний дэд бүтцийг бий болгож, ажил үйлчилгээ эрхлэх газрыг орон нутгийн иргэдэд олгох замаар иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.

000000006

Сер

Болб



- 2.2.3 Баянхонгор аймгийн аялал жуулчлалын салбарын мэдээ мэдээллийг дотоод, гадаадын жуулчдад ил тод нээлттэй, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Цахим - Хөтөх Баянхонгор” төсөл хэрэгжүүлнэ.
- 2.2.4 Баянхонгор аймагт зохион байгуулагддаг аялал жуулчлалын эвент арга хэмжээнүүдийг эрэмбэлж үйл ажиллагааг сайжруулж, эдийн засгийн эргэлтэд оруулах, Их, Бага Шаргалжуут, Их Богд уул, Баянхонгор хот зэрэг нөөц газруудыг түшиглэн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.2.5 Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж байгаа, аж ахуйн нэгж, иргэдийг хүү багатай, хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр дэмжин ажиллана.
- 2.2.6 Баянхонгор аймгийн Хүрэн бэлчир, Цагаан агуй, Бичигт хадыг түшиглэн аялал жуулчлалын цогцолбор байгуулж, Их Богд уул, Их, Бага Шаргалжуут, Θхэг, Θргөөт, Хөх нуур, Биндэръяа хөх нуур зэрэг жуулчид олноор ирдэг газруудын менежментийг сайжруулж дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 2.2.7 Заг, Байдрагийн голын сав газрын дотоод бүсчлэлийг байгуулж аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 2.2.8 Баянхонгор аймгийн хэвтээ болон босоо тэнхлэгийн авто замын дагуу дотоод, гадаадын жуулчдын амрах, түр буудаллах цэгийг төр, хувийн хэвшлийн хамтын оролцоотойгоор байгуулна.

2.3 Дэд бүтэц

Утаагүй- Баянхонгор төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирсын шугам сүлжээнд холбож орчны бохирдлыг бууруулна.


“Сумын хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж, хорооллыг зам, гэрэлтүүлэгтэй болгоно.

Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын эхний ээлжийг дахин төлөвлөлтэд оруулах замаар орон сууцны хороолол барих ажлыг эхлүүлнэ.

Эрчим хүчиний яам, шинжлэх ухааны байгууллагын боловсруулсан 10-50 МВт-ын хүчин чадал бүхий нарны цахилгаан станцын төслийдийг аймагт хэрэгжүүлнэ.

- 2.3.1 Утаагүй- Баянхонгор төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Баянхонгор сумын гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дулаан, цэвэр, бохирсын шугам сүлжээнд холбож орчны бохирдлыг бууруулна.
- 2.3.2 “Сумын хөгжил” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, сумын төвийн айл өрхийг инженерийн шугам сүлжээгээр холбож, гудамж, хорооллыг гэрэлтүүлэгтэй болгоно.
- 2.3.3 Баянхонгор хотын үерийн ус зайлцуулах инженерийн байгууламжтай болно.
- 2.3.4 Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгуудыг буулгаж, шинээр барих ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.3.5 Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын эхний ээлжийг дахин төлөвлөлтэд оруулах замаар орон сууцны хороолол барих ажлыг эхлүүлнэ.
- 2.3.6 Баянхонгор хотын ус хангамжийн төв магистраль шугамыг солино.
- 2.3.7 Баянхонгор хотын цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг олон улсын төсөл хөтөлбөрийн шугамаар шийдвэрлэнэ.

• 000000007

- 2.3.8 Баянхонгор сумын гэр хорооллын айл, өрхүүдийн дунд бохирын нэгдсэн шугам сүлжээ татах, био жорлон нэвтрүүлэх замаар хөрсний бохирдлыг багасгана.
- 2.3.9 "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийг хэрэгжүүлж 200 өрхийг хамруулна.
- 2.3.10 110/35/6кВ-ын Баянхонгор дэд станцын суурилагдсан хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
- 2.3.11 Эрчим хүчний яам, шинжлэх ухааны байгууллагын боловсруулсан 10·50 МВт-ын хүчин чадал бүхий нарны цахилгаан станцын төслүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 2.3.12 Эрчим хүчний шөнийн тарифыг тэглэнэ.
- 2.3.13 Аймгийн төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.
- 2.3.14 Баянхонгор сумын орон сууцны оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулж, орон сууцны ашиглалтыг Сууц өмчлөгчдийн холбоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.3.15 4 сумыг "Шинэ сум" төсөлд хамруулна.

2.4 Авто зам

Баянхонгор хотод "Хөгжлийн хөтөч - Дэд бүтэц" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, 20 км авто зам барих ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.

- 2.4.1 Монгол улсын Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд орсон "Цэцэрлэг хот-Эрдэнэцогт сум- Баянхонгор хот – Баянлиг сум – Гурвантэс сум" хүртэлх 700 км босоо тэнхлэгийн авто замын ажлыг эхлүүлнэ.
- 2.4.2 Баянхонгор хотод "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж 20 км авто замын ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлэнэ.
- 2.4.3 Сум бүрд 2 км хатуу хүчилттай авто зам тавина.
- 2.4.4 Баянхонгор сумын Түйн гол, Бөмбөгөр сумын Улаан сайд, Загийн гол, Хоолтын гармуудад төмөр бетонон гүүр барина.
- 2.4.5 Баянхонгор сум – Шаргалжуут чиглэлийн 56 км авто замыг барина.
- 2.4.6 Баянхонгор сумын газар нутгийг тэлэх зорилгоор нисэх буудлыг нүүлгэж, өргөтгөх судалгааны ажлыг эхлүүлнэ.
- 2.4.7 Агаарын тээврийн хот хооронд зорчигч тээврийн арилжааны тогтмол нислэгийн давтамжийг нэмэгдүүлж, сүмдад нислэгтэй болгоно.

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангаж, чадваржуулан, төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлэх ба төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулна.

- 3.1 Төрийн байгууллага бүрд "Төрийн албан хаагчийн Нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр, төрийн албан хаагчийн "Сургалтын хөтөлбөр"-ийг батлуулан хэрэгжүүлж, "Орон сууц, хашаа, байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулна.
- 3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлнэ.

000000008



- 3.3 Нийгмийн хариуцлагаа ухамсарласан, хараат бус, мэргэжлийн сэтгүүл зүйг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэн, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллана.
- 3.4 Хүнсний бүтээгдэхүүний чанарын баталгааг сайжруулах зорилгоор Мэргэжлийн хяналтын газрыг лабораторийн шинэ техник технологи, багаж хэрэгслээр хангана.
- 3.5 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна.
- 3.6 Мэдээлэл технологийн шинэчлэлийг төрийн үйл ажиллагаанд тасралтгүй нэвтрүүлж, иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах цогц үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.7 Хариуцлагатай төрийн албан хаагч-хариуцлагатай засаглал хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.8 Шинэжинст, Баянцагаан, Баацагаан, Жинст, Хүрээмарал, Гурванбулаг, Заг, Жаргалант, Баян-Овоо сумдад нутгийн удирдлагын ордон, зарим сумдын багийн төвүүдийг шинээр барих, засварлах, өргөтгөх асуудлыг шийдвэрлэж засаг захиргааны анхан шатны нэгжид төрийн үйлчилгээг төвлөрүүлэх арга хэмжээг авна.
- 3.9 Зарим төрийн байгууллагуудад автомашины парк шинэчлэлт хийнэ.
- 3.10 Хууль сахиулах байгууллагын албан хаагчдын ажиллаж амьдрах боломжийг судалж сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.11 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хянах нөхцөлийг сайжруулна.
- 3.12 Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайтай тэмцэхэд иргэн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжих замаар мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.13 Гамшигт үзэгдлүүд (ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга г.м)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулан хэрэгжүүлж, зохих нөөцийг бүрдүүлнэ.
- 3.14 Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдалд зориулалттай эрсдэлийн сан байгуулж, иргэдийн боловсролыг дээшлүүлнэ.
- 3.15 Цэрэг, эх оронч үзэлд суурилсан “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагдах оюутны тоог шат дараатай нэмэгдүүлнэ.
- 3.16 Архигүй Баянхонгор хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.17 Авлигагүй Баянхонгор хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн албыг хүнд суртал, авлигагүй болгоно.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Орон нутгийн экосистем, унаган байгалийн тогтвортой байдлыг хадгалах зорилтын хүрээнд цэнгэг усны нөөц бүхий Байдраг, Түйн голуудын сав газрын урсац бүрэлдэх эхийн 65-аас доошгүй хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах, уул уурхайн салбарын нөхөн сэргээлтэд байгальд эзлтэй дэвшилтэй техник, технологи нэвтрүүлдэг, усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласны болон бусад татвараа хугацаанд нь төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжин ажиллана. Иргэдээ баталгаат ундны усны нөөцөөр хангана.

- 4.1 Усны нөөц, голуудын урсац бүрэлдэх эхийн 65-аас доошгүй хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авна.

• 000000009



- 4.2 Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын менежментийг боловсронгуй болгож, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлтээр хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
- 4.3 Бэлчээрийг нөхөн сэргээх "Малчдын дундын сан" байгуулна.
- 4.4 Түүх, соёлын дурсгалт газар, ус, ой, эко систем, ховор амьтан, ургамлын тархац бүхий нутаг, өвөрмөц тогтоцтой эко системийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авч, тухайн бүс нутагт ажиллаж амьдарч буй иргэд, малчдын бүлэг, нөхөрлөлтэй хамтран ажиллаж, хамгаалалтын оновчтой бодлого хэрэгжүүлнэ.
- 4.5 Сум, суурин газрын 80 орчим хувийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангана.
- 4.6 Баянбулаг, Шинэжинст сумын цаг уурын шинжилгээний өртөөний барилгыг шинээр барина.
- 4.7 Гол, горхи, булаг, шандын эх, гүний худгуудын хамгаалалтын бүсэд болон цөлжилт, элсний нүүдэлд автаж хөрсний элэгдэлд орсон газруудад гүнээс чийг татаж амьдрах чадвартай заг, тоорой, сухай, хайлаас зэрэг модлог болон харгана, торлог, тэсэг, шаваг, шар мод тарьж ногоон хэрэм бий болгоно.
- 4.8 Ашиглагдаагүй байгаа бэлчээр нутагт худаг гаргах, булаг шанд, цас борооны ус хуримтлуулж хөв цөөрөм байгуулах хэлбэрээр усны нэмэлт эх үүсвэрийг бий болгож, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг усжуулсан, ойжуулалт хийсэн малчдын бүлэг, хоршоо, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн санал санаачилгыг дэмжиж, санхүүгийн дэмжлэг олгох, урамшуулах механизмыг бий болгоно.
- 4.9 Баянхонгор сумын Эрдэнэмандал хайрхны орчныг цэцэрлэгжүүлж арцат, ногоон бүс болгоно.
- 4.10 Аймгийн төв болон сумдын оршуулгын газруудын газар олголтыг цэгцэлж, орчин үеийн шарил чандарлах технологийг нэвтрүүлнэ.
- 4.11 Байгаль орчны салбарын нэгдсэн оффисын барилгыг барьж ашиглалтад оруулна.
- 4.12 Нөхөн сэргээлтэд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, усыг дахин ашигладаг, байгалийн нөөц ашигласны болон бусад төлбөрөө хугацаандаа төлдөг хариуцлагатай уул уурхайг дэмжинэ.
- 4.13 Бичил уурхайтай холбоотой асуудлыг цэгцэлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох саналыг эрх барих дээд байгууллагаар шийдвэрлүүлэн, бичил уурхайчдад ээлтэй бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.14 Нөхөн сэргээлт нэрээр хууль бус алт олборлолтыг таслан зогсоон.
- 4.15 "Баянхонгор – Ногоон хот", "Баянхонгор–Цэвэр хот" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хотын өнгө үзэмжийг сайжруулна.
- 4.16 Баянхонгор хотын Түйн голын сав дагуу Амралт зугаалгын бүс байгуулна.

ТАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙ

Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлэн, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шимийг сайжруулах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ.
- 5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимиийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг

000000010



- шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлнэ.
- 5.3 Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлж, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх цахим тогтолцоог хөгжүүлж өргөжүүлнэ.
- 5.4 Иргэдээ орон нутагт үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, талх, нарийн боов, жимс, жимсгэнээр хангах "Органик хүнс" төсөл хэрэгжүүлж, өрхийн тариалалтыг дэмжиж дотоодын хэрэгцээний тодорхой хувийг хангана.
- 5.5 Нутгийн шилмэл омог, үүлдрийн малыг өсгөн, эдийн засгийн эргэлтэд оруулж, таваарлаг чанарыг сайжруулна.
- 5.6 Малын халдварт өвчин тархах, давтамжийн судалгааг үндэслэн мал эмнэлгийн цогц арга хэмжээг эрчимжүүлж, эрүүл бүс нутаг гэсэн статусаа баталгаажуулна.
- 5.7 Аймгийн хэмжээнд атаршсан талбайд үр тариа, жимс, жимсгэнэ, малын тэжээл, бут сөөг тариална.
- 5.8 Услалтын системүүдийн ашиглалтыг сайжруулж, төмс хүнсний ногоо, тэжээлийн болон эмийн ашигт ургамал тариалах бодлогыг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 5.9 Махны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор гахай, тахианы аж ахуй байгуулах санал, санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 5.10 Мах, сүүний чиглэлийн мал үржүүлэх бүс нутгуудын малыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэн тодорхой үр дүнд хүргэж, "Эрүүл бүс" нутагт тавигддаг олон улсын шаардлагуудыг хангаж зах зээлд зарлана.
- 5.11 Заг, Байдрагийн голын гадна болон дотоод орчны бэлчээрийн менежментийн төлөвлөлтийг батлуулж, тусгай журмыг батлан хэрэгжүүлнэ.

ооо



000000011

